



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2014 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Өргөдлийн байнгын хорооны 2014 оны 05 дугаар сарын 7, 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

### **Хэлэлцсэн нь:**

Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 70 тоот шийтгэх тогтоол, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 285 тоот магадлал, Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны шүүхийн 2013 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 312 тоот тогтоолоор хүчингүй болсон ашигт малтмалын 106 тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар ирүүлсэн өргөдлийг хэлэлцэв. Байнгын хорооны хуралдаанаар асуудлыг хэлэлцэх үед:

**Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Ч.Хүрэлбаатар нар:** “Хуулийн зохицуулалт зөрчилтэй, учир дутагдалтай байгаагаас иргэд, аж ахуйн нэгж хохирсон асуудал байвал Өргөдлийн байнгын хороо авч үзэх ба холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэлэлцэх үед саналаа тусгуулах талаар ажиллах хэрэгтэй. Харин тусгайлсан этгээдүүдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг холбогдох эрх бүхий этгээд шийдвэрлэх нь зүйтэй”,

**Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг:** “Өнөөдөр уул уурхайн салбарын бодлого, зохицуулалтыг урт, дунд хугацаанд тогтвортой тодорхойлохоор ажиллаж байгаа үед өнгөц шийдвэр гаргаж болохгүй. Шүүхийн шийдвэрийг хүндэтгэх, хууль эрх зүйн орчиндоо нийцүүлэн Засгийн газар эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх хэрэгтэй.”,

**Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа:** “Эдгээр аж ахуйн нэгжүүд төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас хохирсон гэж үзэж байгаа бол Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсэгт заасны дагуу иргэний хэргийн шүүхэд хохирол нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг гарган шийдвэрлүүлэх эрх нээлттэй байна”,

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** “УИХ хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих 2 чухал үүрэгтэй. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхэд Өргөдлийн байнгын хороо чухал үүрэгтэй. Өнгөрсөн хориод жилд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тал нь орхигдож, ард иргэдийг хохироогоод байхад парламент нь юу ч хийж чадахгүй явж ирсэн. Энэ байдлыг таслан зогсоё гэж Өргөдлийн байнгын хороог байгуулсан. Хууль гарсны дараа хууль хэрэгжүүлэгч нарт зохих хяналтыг тавьж чадахгүй л бол тэр хууль амьгүй хууль болно. Надад 4600 гаруй өргөдөл, гомдол ирсний дотор энэ 106 лицензийн улмаас ажилгүй болсон, хохирсон гэсэн хүмүүсийн өргөдлүүд байна. Хуулийг зохих ёсоор хэрэгжүүлэхгүй байгаа этгээдүүдэд ингэж нугалаа гаргаж болохгүй шүү гэдэг талаар бид жишиг тогтоон шийдвэрлэж өгөх ёстой.”

**Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа:** “Засгийн газрын түвшинд уг асуудлыг шийдвэрлэхээр Уул, уурхайн яам, Хууль зүйн яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уул уурхайн сайдаас 2014 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 1/1090 тоот албан бичгээр “...Ажлын хэсэг ашигт малтмалын 106 тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.2-т зааснаар Засгийн газрын эрх олгосноор Уул уурхайн сайд, Хууль зүйн сайд нарын хамтарсан тушаалаар төсөвт хүндрэл учруулахгүй, сонгон шалгаруулалтад оролцогчдын тэгш байдлыг хангасан, төр болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд эд хөрөнгийн хохиролгүй байдлаар шийдвэрлэхээр тусгайлсан нэг удаагийн сонгон шалгаруулалтын журам батлуулах Засгийн газрын тогтоол гаргуулахаар тогтоолын төслийг боловсруулаад байна” гэсэн мэдээлэл ирүүлжээ. Мөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлээд байна. Иймд сонгон шалгаруулалт явуулах журмаар шийдвэрлэх нь зүйтэй” гэсэн саналыг тус тус гаргав.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Байнгын хорооны хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх үед гишүүдийн гаргасан дээрх саналуудтай уялдуулан дараах агуулга бүхий заалтыг тусгах саналыг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж, хуралдаанд Өргөдлийн байнгын хороог төлөөлөн оролцох гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, О.Содбилэг нарыг томилов. Үүнд:

1.1.Ашигт малтмалын салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох шалгуур, шаардлага, зохицуулалтыг тодорхой болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлага, түүнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр анхаарч, нарийвчлан тусгах.


2.Уул уурхайн яамны саналыг харгалзан тус аж ахуйн нэгжүүдээс Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэх талаар дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгохоор тогтов. Үүнд:

2.1.Эдгээр аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлэх боломжийн талаар аж ахуйн нэгж тус бүрээр нарийвчлан авч үзэж, оновчтой шийдвэрлэх арга хэмжээг шуурхай авах;

2.2.Асуудлыг шийдвэрлэхэд хууль, шүүхийн шийдвэрт нийцүүлэн сонгон шалгаруулалт явуулах, улсын төсөвт хүндрэл учруулахгүй байхад анхаарах, өмнө тухайн талбайд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтад оролцох эрхийг нь хангах, тэдгээрийн оруулсан хөрөнгийг харгалзан үзэж шийдвэрлэх.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

БАЙНГЫН ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.БУРМАА

Х.БАТТӨГСӨХ